

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ДҮҮРГИЙН УДИРДЛАГУУД БОЛОН АЛБАН ТУШААЛТНУУДЫН ИРГЭДТЭЙ ХИЙСЭН УУЛЗАЛТЫН 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот


Сард 2 удаа Засаг дарга болон дүүргийн удирдлагууд иргэд хүлээн авах уулзалтыг зохион байгуулж, уг уулзалтаар гарч буй иргэдийн гомдол, санал, хүсэлтийг тэмдэглэл хөтлөн шийдвэрлэлтэнд хяналт тавин ажиллаж байна.

2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийг дуустал Засаг дарга нийт 214 иргэнийг хүлээн авч уулзаж, тэдний өргөдөл хүсэлтийг хүлээн авч шууд шийдвэрлэх боломжтой өргөдөл, гомдол, санал хүсэлтийг холбогдох мэргэжилтнүүдийг нь байлцуулан асуудлыг тухай бүрт нь шийдвэрлэн, судалж үзэн шийдвэрлэх шаардлагатай бичгээр хандсан өргөдөл, хүсэлтийг өргөдөл гомдлын нэгдсэн программд бүртгэж, хуулийн хугацаанд шийдвэрлэн иргэдэд холбогдох хариуг өгч ажилласан.



Уулзалтаар 60 буюу 28 % эмчилгээний мөнгөн тусламж буюу шагнал урамшуулалд хамрагдах хүсэлт, 34 буюу 15,9 % АОС хамрагдах хүсэлт болон нийгмийн халамжийн үйлчилгээний асуудлаар хамгийн их хандсан байна.

Мөнгөн тусламж дэмжлэг хүссэн иргэнд мөнгөн тусламж үзүүлж, төрийн одон медалиар шагнуулах хүсэлт гаргасан иргэдийн материалыг бүрдүүлж холбогдох журмын дагуу ажилласан.



Дахин төлөвлөлтөд орж байгаа орон сууцны оршин суугчид болон аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийн дагуу дүүргийн 1, 3, 4 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны 7, 8, 9, 10, 11, 12, 22, 23, 24, 37, 35, 36 дугаар барилгыг дахин төлөвлөн барилгажуулах ажлын хүрээнд төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын төслийн явцтай танилцах уулзалт хурлыг сууц өмчлөгч иргэдийн саналын дагуу 2018 оны 06 дугаар сард 1, 3, 4 дүгээр хорооны Иргэний танхимд зохион байгуулсан.

Иргэдийн хүсэлтийн дагуу зөвшөөрөлгүй байршуулсан 70 гаруй ТҮЦ контейнерыг нүүлгэн шилжүүлсэн.



Иргэдтэй хийж байгаа уулзалтын мэдээг сар бүр www.bgd.mn цахим хуудсаар мэдээлж ажилласан.

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Х.МӨНХЗУЛ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ӨРГӨДӨЛ ГОМДОЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Д.ГЭРЭЛЭЭ